



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 02 дугаар сарын 21

№ 01/37 ДУА-2018/22/СТА -ОИТС Мандалговь хот

Г Зөрчлийг арилгуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1-д тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Өлзийт сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

1. Авлага барагдуулалтаас орсон орлогын зарцуулах эрхийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсан боловч түүнийг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлээгүй, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулсангүй 3,000,000.00 /Гурван сая/ төгрөгийг зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, 66 дугаар зүйл-д /Сум дүүргийн засаг даргын бүрэн эрх;/, 66.1.4.-т /иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш ажлын долоон өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;/, заасныг тус тус зөрчсөн байна.

2. Сангийн хөрөнгөөс 2,500,000.00 /хоёр сая таван зуун мянган/ төгрөгийг сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, жагсаалтар эрэмбэлэгдээгүй, зориулалт бус “Цагдаагийн торгуулийн тоног төхөөрөмж” зардал зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5.-д /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/, 60 дугаар зүйлийн 60.3-т /Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг нөриглөно/, 60.3.1.-д /орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ/, 60.3.6-д /орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ/ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын эжилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95

дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.4-т /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зөрчсөн;/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ НЬ:

1. ОНХС-ийн хөрөнгөөр 2018 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт, орлогын эх үүсвэрийг батлуулж аймгийн Засаг даргад хүргүүлсэн эсэхэд хяналт тавьж хэрэгжүүлэх;
2. Цаашид сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан орон нутгийн төсвийг түүнийг баталснаас хойш хуульд заасан хугацаанд аймгийн Засаг даргад хүргүүлж хэвших.

Албан шаардлагын биелэлтийг 2018 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг Өлзийт сумын Засаг дарга А.Эрдэнэбат, Засаг даргын орлогч О.Ган, Санхүүгийн албаны дарга Б.Болдбаатар, нягтлан бодогч Н.Буянжаргал нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ



Д.ИХБАЯР

ЗӨВШӨӨРСӨН:

ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭБАТ
ОРЛОГЧ ДАРГА О.ГАН
САНХҮҮГИЙН АЛБАНЫ ДАРГА Б.БОЛДБААТАР
НЯГТЛАН БОДОГЧ Н.БУЯНЖАРГАЛ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д “Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрээт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ” гэж заасны дагуу хариуцаач албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.